



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 07 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар ХЭГ/1856

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР ТАНАА


Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын гадаад өрийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид баримтлах бодлогын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.


Хавсралт: 6 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021509747



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 07 дугаар сарын 22 ны өдрийн
Хар/1856 дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТТӨМӨРӨӨС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Шинээр арилжааны нөхцөлтэй гадаад зээл авахаа зогсоосноор төсөвт үзүүлэх дарамт буурч, энэ онд зээлийн хүүгийн зардал төсвийн зарлагын 7.1 хувь, 2022 онд 6.2 хувь болох зорилт, тооцоолол бий. Энэ зорилт, тооцоолол хангагдаж байгаа эсэх талаар болон уг зорилтыг хангахын тулд ямар арга хэмжээ авч байгаа талаар

Бодлогын арга хэмжээ: Засгийн газрын зүгээс Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т тусгагдсан дунд хугацааны зорилтын хүрээнд “Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах бодлого”-ыг баримтлан ажиллаж байна.

Хэрэгжилт: Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт заасан 1 дүгээр зорилтын хүрээнд Засгийн газар 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 600.0 сая ам.долларын “Номад” бондыг 5.125 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд арилжаалж 2021 оны 4 дүгээр сард төлөгдөх хуваарьтай 500.0 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөгдөх хуваарьтай 1.0 тэрбум ам.долларын Чингис бондын тодорхой хэсгийг тус тус буцаан худалдан авч өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын эдийн засаг 2020 онд 5.3 хувийн агшилттай, зээлжих зэрэглэл В түвшинтэй байгаа цар тахлын хэцүү цаг үед бид “Century” төслийн хүрээнд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтыг амжилттайгаар хэрэгжүүлж, ирэх 2 жилийн өр төлбөрийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,159.3 тэрбум төгрөг, үүнээс үндсэн төлбөрт 804.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 355.0 тэрбум төгрөгийг төлж барагдуулсан. Гадаад зээлийн төлбөрт 426.6 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны төлбөрт 377.7 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны төлбөрт 64.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Том дүнтэй төлбөрүүдээс дурдвал, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сард авсан “Кредит Свисс” банкны 6.5+LIBOR 6 сар хувьсах хүүтэй 250.0 сая ам.долларын арилжааны нөхцөлтэй зээлийн үлдэгдэл 60.0 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 61.9 сая ам.доллар буюу 176.4 тэрбум төгрөгийг төлсөн. Мөн 2016 оны 4 дүгээр сард арилжаалсан 10.875 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын Мазаалай бондын үлдэгдэл болох 132.6 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 139.9 сая ам.доллар буюу 398.3 тэрбум төгрөгийг төлж барагдуулсан. 2021 оны эхний улиралд шинээр арилжааны нөхцөлтэй өр үүсгэлгүй хуучин үүссэн хүүгийн түвшин өндөртэй өрийг шийдвэрлэх өрийн зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа болно.

Шинээр арилжааны нөхцөлтэй гадаад зээл авахаа зогсоосноор төсөвт үзүүлэх дарамт буурч 2021 оны төсвийн тодотголоор зээлийн хүүгийн зардал төсвийн зарлагын 6.1 хувьтай тэнцэхээр байна.

Асуулга 2. Цаашид энэ чиглэлээр эрсдэлээс сэргийлж, нөөц бий болгох, гадаад өрийг өсгөхгүй барьж, бууруулах чиглэлээр ямар бодлого баримтлан ажиллаж байгаа талаар

Бодлогын арга хэмжээ: Засгийн газрын зүгээс Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т тусгагдсан дунд хугацааны зорилтуудын хүрээнд “Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулах бодлого”-ыг баримтлан ажиллаж байна.

Хэрэгжилт: Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2021 оны эхний улирлын байдлаар 32.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6 хувиар буюу 1,970 сая ам.доллараар нэмэгдэж, Засгийн газрын өрийн үлдэгдэл 8.45 сая ам.долларт хүрсэн байна.

Гадаадаас авсан арилжааны нөхцөлтэй зээллэгийн хүрээнд өнгөрсөн 9 дүгээр сард олон улс дахь зах зээлд 600 сая ам.доллартай тэнцэх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 2021 оны 6 дугаар сарын сүүлээр “Century” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан Чингис болон Гэрэгэ бондын 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Монгол Улс 2011-2012 онд эдийн засгийн өсөлт 17.3 болон 12.3 хувьтай, зээлжих зэрэглэл өнөөгийн түвшнээс 2 зэрэглэл дээгүүр байсан эдийн засгийн оргил үедээ 10 жилийн хугацаатай, 5.125 хувийн хүүтэй, 1 тэрбум ам.долларын Чингис бондыг гаргасан бөгөөд энэхүү бондын эргэн төлөлт нь ирэх жил хийгдэх байсан. Энэ удаад Монгол Улсын эдийн засаг 2020 онд 5.3 хувийн агшилттай, зээлжих зэрэглэл В түвшинтэй байгаа цар тахлын хэцүү цаг үед бид “Century” төслийн хүрээнд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй, 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтыг амжилттайгаар хэрэгжүүлж, ирэх 2 жилийн өр төлбөрийг шийдсэн. Засгийн газар хугацаа тулсан, өндөр дүнтэй гадаад өр төлбөрийг хойшлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх жилүүдэд үүсэх байсан өрийн дарамтыг бууруулж, гадаад валютын ханшийг тогтвортой барихад эерэг нөлөө үзүүлэх төдийгүй Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад чухал нөлөөтэй юм.

Үр дүн: Засгийн газар нэг болон олон талт зээлдүүлэгч байгууллага, олон улсын хөрөнгө оруулагчдаас авсан хөнгөлөлттэй болон арилжааны нөхцөлтэй зээллэгийн төлбөрийг ийнхүү дотоодын эх үүсвэрээр эдийн засаг, төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт багатайгаар төлж барагдуулснаар хөрөнгө оруулагчдын Монгол улсад итгэх итгэлийг нэмэгдүүлж, Монгол улсын эдийн засаг, төлбөрийн тэнцлийн талаарх эерэг хүлээлтийг үүсгэн, цаашид зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх, гадаад санхүүжилтийн өртгийг бууруулах зэрэг эерэг нөлөөллийг үзүүлэхээр байна.

Асуулга 3. Гадаад зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ өндөр байгаа энэ үед өрийг барагдуулах чиглэлээр Засгийн газраас ямар бодлого баримтлан ажиллаж байгаа талаар

Бодлогын арга хэмжээ: Засгийн газрын зүгээс Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т тусгагдсан дунд хугацааны зорилтуудын хүрээнд өр төлбөрийг төсөв, эдийн засагт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, арилжааны нөхцөлтэй гадаад зээллэг болон болзошгүй өр

төлбөрийн хэмжээг бууруулах, улмаар улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Хэрэгжилт: Төсвийн тодотголд Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн нийт орлого 13 их наяд 731.7 тэрбум төгрөг, зарлага 15 их наяд 748.3 тэрбум төгрөг болж төсвийн алдагдал 3 их наяд 691.8 тэрбум төгрөгт хүрсэн Ковидын нөхцөл байдлаас үүдэн эдийн засаг хүндхэн байгаа энэ үед “Номад” бондыг 5.125 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд арилжаалж 2021 оны 4 дүгээр сард төлөгдөх хуваарьтай 500.0 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөгдөх хуваарьтай 1.0 тэрбум ам.долларын Чингис бондын тодорхой хэсгийг буцаан худалдан авч өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Засгийн газраас арилжааны банкинд өндөр хүүтэй дотоод бонд нийлүүлж байсныг зогсоож зах зээл дэх зээлийн эх үүсвэрийг 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн, Төвбанкнаас бодлогын хүүг үе шаттай бууруулсан зэргээс шалтгаалан зээлийн хүүгийн түвшин 17.6 хувьд хүрч буурсан нь 2013 оны 12 дугаар сараас хойшхи хамгийн бага түвшинд хүрлээ.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс өр барагдуулах чиглэлийн хүрээнд дотоодын зах зээл дээр хүүгийн түвшин өндөр хүүтэй Засгийн газрын дотоод үнэт цаасыг буцаан худалдан авах арга хэмжээг 2018 оны сүүлээр зохион байгуулж Засгийн газрын дотоод өрийн үлдэгдлийг 3,461.9 тэрбум төгрөг байсныг бууруулан 2018 оны жилийн эцсийн үлдэгдлээр 1,564 тэрбум төгрөгт хүртэл бууруулсан 2021 оны эхний улирлын байдлаар Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл 1,136.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын зүгээс Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 2021 оны 1-4 дүгээр сар хүртэл нийт 1,005.8 тэрбум төгрөг, үүнээс үндсэн төлбөрт 765.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 240.4 тэрбум төгрөгийг төлж барагдуулсан. Гадаад зээлийн төлбөрт 424.8 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны төлбөрт 517.1 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны төлбөрт 64.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Том дүнтэй төлбөрүүдээс дурдвал, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сард авсан “Кредит Свисс” банкны 6.5+LIBOR 6 сар хувьсах хүүтэй 250.0 сая ам.долларын арилжааны нөхцөлтэй зээлийн үлдэгдэл 60.0 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 61.9 сая ам.доллар буюу 176.4 тэрбум төгрөгийг төлсөн. Мөн 2016 оны 4 дүгээр сард арилжаалсан 10.875 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын Мазаалай бондын үлдэгдэл болох 132.6 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 139.9 сая ам.доллар буюу 398.3 тэрбум төгрөгийг төлж барагдуулсан.

Асуулга 4. Гаднаас авч буй зээл эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байр бий болгох гэх мэт зөв зохистой зүйлд зарцуулагдаж байж үр ашгаа өгдөг. Энэ чиглэлээр Засгийн газраас ямар бодлого баримтлаж ажиллаж байгаа талаар

Бодлогын арга хэмжээ: Засгийн газрын зүгээс Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т тусгагдсан дунд хугацааны зорилтуудын хүрээнд “Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулан үр ашигтай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого”-ыг баримтлан ажиллаж байна.

Хэрэгжилт: 2017-2020 оны хооронд хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн томоохон төслүүд дурьдвал: Шинэ нисэх онгоцны буудал төсөл (Япон

471.9 тэрбум төгрөг), Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэл төсөл (БНХАУ 276.4 тэрбум төгрөг), Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км автозам барих төсөл (БНХАУ 151.1 тэрбум төгрөг), Тосонцэнгэл- Улиастай чиглэлийн 114 км автозам барих төсөл (АХБ 191.1 тэрбум төгрөг), Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах дэд станц барих төсөл (БНХАУ 279.2 тэрбум төгрөг) болон Үндэсний оношлогоо эмчилгээний төв байгуулах төслүүдийг (Солонгос 88.8 тэрбум төгрөг) тус тус 25-40 жилийн хугацаатай 0.1%-2% хүүтэйгээр, 5-10 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаатайгаар авч хэрэгжүүлээд байна.

Сүүлийн жилүүдэд шинээр хэрэгжих хөнгөлөлттэй зээлийн тоо, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж байгаа тул зөвхөн эдийн засаг, нийгмийн үр ашигтай төслүүдийг сонгон санхүүжүүлэх шаардлага бий болж нэн шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрийг ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжийг харгалзан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Энэ шаардлагын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дараах эдийн засгийг сэргээх “100+” төсөл, арга хэмжээ”-ний талаар танилцуулгыг Сангийн яамнаас Засгийн газрын гишүүдэд танилцуулж, жагсаалтын төслийг хувийн хэвшил, олон улсын байгууллага, олон нийтэд танилцуулахыг даалгасан. Энэ хүрээнд жагсаалтад багтаж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах боломжтой, эдийн засгийн үр өгөөж бүхий 33 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжит арга, хэлбэрийг дараах үндсэн 9 төрөлд хуваасан. Үүнд:

- Төрийн өмчит хувьцаат компанийн санхүүжилтээр шийдвэрлэх боломжтой 15.8 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл;
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих болон хэрэгжиж буй 7.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл;
- Хөрөнгө оруулагчдад нээлттэй санал болгож болохуйц 8.7 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл;
- Төр, хувийн хэвшлийн түншлэл болох “Барих – Ашиглах - Шилжүүлэх” нөхцөлөөр хэрэгжих болон хэрэгжиж буй 7.0 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл;
- Төрийн зүгээс дэд бүтэц, газар, ерөнхий зураглалыг хариуцаж, хувийн хэвшил үйлдвэржилт, бүтээн байгуулалтыг хариуцах замаар төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжих болон хэрэгжиж буй 2.9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл;
- Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжиж буй 433 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл;
- Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байгаа 3.5 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл;
- Бусад санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжих 2.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл.

Дээрх төслүүдээс санхүүжилтийн арга, хэлбэрийг яаралтай олж тодорхойлох шаардлагатай байгаа дараах 5 төслийн хүрээнд төслийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д үндэслэн холбогдох яамдтай хамтран төслийн санхүүгийн мөнгөн урсгалд шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар саналыг танилцуулсан.

Иймд нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан сонгосон эдгээр 100 төсөл, арга хэмжээг улсын төсөв, Засгийн газрын өрд дарамтгүйгээр, хувийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэлийн арга хэлбэрүүдийг ашиглан хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилээс жигд зохион байгуулж эхлүүлэх,

эрчимжүүлэх арга хэмжээ авах нь нэн чухал байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллага, хөгжлийн түншүүдээс авах хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үр ашиг, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хийгдэх судалгаа, шинжилгээг сайжруулж, хуулиар тогтоосон өрийн хязгаарт багтаан эдийн засаг, нийгмийн хувьд хамгийн үр өгөөжтэй байх төслүүдийг сонгон хэрэгжүүлэх үүднээс 2021 оны 6 дугаар сард бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт шинээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үе шатууд болон шаардлагыг хүргүүлсэн болно.

Асуулга 5. Экспортод гарч буй түүхий эдийн боловсруулалтыг нэмэгдүүлэх замаар үнэ, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, энэ чиглэлээр цаашид ямар бодлого баримтлан ажиллах талаар

Бодлогын арга хэмжээ: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа-2050 бодлогыг баталсан. Түүний 4.2 дугаар зорилтод “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.” гэж заасан байдаг. Энэ хүрээнд эхний үе шат буюу 2021-2030 оны хугацаанд зорилтыг хангахаар бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

- 1.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлэх,
- 2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
- 3.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх.

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлэх чиглэлээр: Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой арга зарчмаар хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг нэвтрүүлэх, Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээг барьж байгуулах, Нүүрс баяжуулах, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслүүдийг зарлан хэрэгжүүлж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар нь ажиллах хүчний гуравны нэг, ДНБ-ий 11 хувийг бүрдүүлдэг эдийн засгийн чухал салбар юм. 2020 оны байдлаар 67 сая гаруй мал тоолуулсан асар их мал аж ахуйн нөөцтэй Монгол Улсын хувьд малын гаралтай мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэрэг бараа бүтээгдэхүүнүүдийг дэлхийн зах зээлд гаргаж, эдийн засгаа өсгөх асар их боломж бий. Үйлдвэрлэлийн нөөц болон дотоодын зах зээлийг харьцуулж үзвэл, манай улс тогтвортой мал аж ахуй, газар тариалангийн салбарт түшиглэсэн экспортын баримжаатай хүнс, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой. Иймд Засгийн газраас уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан шинэ түвшинд хөгжүүлж, хүн амын хүнсний хэрэгцээг хангахаас гадна, эрүүл органик хүнсний экспортыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд малыг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, мал амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хийж байна.

Үндэсний онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр: Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх, зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлэх, Хөвсгөл нуурын БЦГ-т “Тогтвортой аялал жуулчлал”-ыг хөгжүүлж, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк”, Хэнтий аймагт “Мянганы суут хүн их эзэн Чингис хаан”, “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн”, “Шихихутаг нууц товчоо”, “Хүлэгбаатар Боорчи - Андлалын Өргөө”, “Монголын нууц товчоо” зэрэг аялал жуулчлалын цогцолборуудыг барих, Баруун бүсэд-Адал явдалт, тусгай сонирхлын, Хангайн бүсэд-Байгалийн, амралт зугаалгын, Төвийн болон Улаанбаатарын бүсэд-Албан, бизнесийн, Говийн бүсэд-Байгалийн, палеонтологийн, Зүүнбүсэд-Түүхэн (биет соёлын өвүүдэд тулгуурласан) аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх, Баруун бүс, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк” байгуулах ажлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж эхлүүлээд байна.

-----oOo-----